



BUYANT-UKHAA
INTERNATIONAL AIRPORT

“БУЯНТ-УХАА” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 4/23.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.26.1 дэх заалт, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын “Аэродромын ерөнхий заавар”-ын 4 дүгээр бүлгийн 4.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал болон нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аюултай нөхцөл байдал үүсэхээс өмнө засаж залруулах, үйл ажиллагаанд гарч болзошгүй аюулыг тодорхойлж, эрсдэлийг удирдахтай холбоотой “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж, мөрдөн ажиллахыг аюулгүй ажиллагааны хорооны нарийн бичгийн дарга (Ө.Жанчив, Ч.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ОТГОНЖАРГАЛ

“Буянт-Ухаа” олон улсын нисэх
буудлын даргын 2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдрийн 4/23 дугаар
тушаалын хавсралт



“САЙН ДУРЫН МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЙРЦАГ” АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын Аюулгүй ажиллагаатай холбоотой алдаа, дутагдал, үл тохирлын талаарх “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг ажиллуулах журам”-ын зорилго нь нисэх буудал болон нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үүссэн алдаа, дутагдал, дүрэм журмын үл биелэлт болон аюултай нөхцөл байдлыг урьдчилан илрүүлэх, осол болохоос өмнө засаж залруулахад оршино.

Хоёр. “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг”-т цугларсан мэдээллийг хүлээн авах, бүртгэх

- 2.1. Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцагт иргэд, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын ажилтан, албан хаагчид болон тус нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагын ажилтнуудаас нисэхийн аюулгүй ажиллагаатай холбоотой зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авна.
- 2.2. Аюулгүй ажиллагааны хорооны нарийн бичгийн дарга бөгөөд тус нисэх буудлын Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт, хяналтын нэгжийн мэргэжилтэн нь сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцгийг 7 хоногт 3 удаа шалгаж, ирсэн мэдээллийг бүртгэн, нэгтгэж Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэст хүргүүлнэ.
- 2.3. Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн нь сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг дээрх QR кодын дагуу ирсэн мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ хийж Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт, хяналтын хэсгийн мэргэжилтэнд өгч бүртгүүлэн, “Аюулгүй ажиллагааны хороо”-ны дарга болон дэд даргад танилцуулна.

Гурав. Үүрэг

- 3.1. Аюулгүй ажиллагааны хорооны дарга нь иргэд болон ажилтан албан хаагчдыг нисэх буудал болон нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үүссэн алдаа дутагдал, үл тохирлыг сайн дураар мэдээлэх боломжоор хангах үүргийг хүлээнэ.
- 3.2. Аюулгүй ажиллагааны хорооны дарга нь “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг”-т ирсэн мэдээлэл болон засаж залруулах арга хэмжээнд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллана.

- 3.3. Нисэх буудлын Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалт, хяналтын нэгжийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг”-ийг байгууллагын хэмжээнд байнгын идэвхтэй байлгах, үүргийг хүлээнэ.
- 3.4. Дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн нь сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг дээрх QR кодын үйл ажиллагааг байнгын идэвхтэй ажиллуулах үүргийг хүлээнэ.

**Дөрөв. Нисэх буудал болон нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны
дутагдал, үл тохирлыг сайн дураар мэдээлэх
боломжоор хангах**

- 4.1. Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцгийг “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын байранд нүдэнд ил харагдахуйц, мэдээлэл өгөхөд хялбар гар хүрэхүйц газар байрлуулна.
- 4.2. Иргэд болон ажилтнууд нь санамсаргүй гаргасан, илрүүлсэн үл тохирол, дутагдлын талаарх мэдээллийг “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг”-т бичгээр ирүүлэх эсхүл **хайрцаг дээрх QR** код уншуулан бөглөх буюу аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтнуудад дараах дугаарт болон цахим хаягаар сайн дураар мэдээлж болно. Үүнд:

71-28-3047 (Нислэг үйлдвэрлэлийн зохицуулагч-НҮЗ)

71-28-3079 (ҮТЗХХ-ийн мэргэжилтэн)

1dxaax@gmail.com (ДХААХ-ийн мэргэжилтэн)

- 4.3. Сайн дурын мэдээллийн тогтолцоо нь шийтгэлээс ангид байх ба мэдээллийн эх сурвалжийг хамгаалдаг байх зарчмыг баримтална.
- 4.4. Аюулгүй ажиллагааны алдаа, дутагдалтай холбоотой мэдээллийг сайн дураар дамжуулсан иргэний хувийн мэдээллийг чандлан нууцална.
- 4.5. “Сайн дурын мэдээлэл хүлээн авах хайрцаг”-т болон аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтнуудад нисэх буудал болон үйл ажиллагаанд нэн аюултай нөхцөл байдал үүсэж болзошгүй тухай мэдээлэл дамжуулсан ажилтанд аюулгүй ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь үнэлж нисэх буудлын “Аэродромын ерөнхий заавар”-ын 4.1.5.1.9-д заасны дагуу урамшуулан дэмжинэ.